



ХЭНТИЙ АЙМГИЙН БЭРХ ХОТ



ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

1954 оны 09-р сарын 12-нд анх Бэрхийн уурхай байгуулагдаж, хүн амын суурьшил бий болсонтой холбогдуулан БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1958 оны 34-р зарлигаар Бэрхийн хороог байгуулсан юм. 1990 он хүртэл Бэрхийн хорооны АДХГЗахиргааны даргыг Бэрхийн уурхайн дарга хавсран хашиж, харин АДХГЗ-ны нарийн бичгийн дарга нь орон тоогоор ажиллан төрийн ажлыг гүйцэтгэдэг байв. 1990 оноос төрийн байгууллагыг аж ахуйн нэгжээс тусгаарлаж, Бэрхийн АДХГЗахиргаа бие даан ажиллах болсон. 1994 онд батлагдсан Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг үндэслэн Монгол Улсын их хурлын 1994 оны 7-р сарын 4-ний өдрийн 58 дугаар тогтоолоор Бэрх хот болгон өөрчилснөөс хойш одоо хүртэл Хэнтий аймгийн Батноров сумын 7-р баг бөгөөд Хэнтий аймгийн Бэрх хот хэмээн албан ёсоор нэрлэгдэж байна.

Бэрх хот нь 2313 хүн амтай, **76365** толгой малтай бөгөөд Дэд бүтэц түлхүү хөгжсөн 27 айлын 18 орон сууцны байр, 500 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай ЕБСургууль, 200 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай Хүүхдийн цэцэрлэг, мөн 400 хүний суудалтай Соёлын ордон, 2017 оны 09 сард ашиглалтанд орсон 8 айлын орон сууцтай Онцгой байдлын гал унтраах, аврах 42-р анги, Сум дундын нэгдсэн эмнэлэг, Сум дундын Цагдаагийн тасаг зэрэг төсөвт байгуулагуудаас гадна “Бэрх-Уул” ХК, “Хэнтий-Ус” ХХК-ны харъяа Дулааны станц, Цахилгаан шугам сүлжээний хэсэг, ХААН, Хадгаламж банкны

салбарууд, Шуудан тасаг, кабелийн телевиз, ахуй үйлчилгээний төв, “Ник тос” ХК-ны салбар шатахуун түгээх станц, хүнсний зах болон худалдаа үйлчилгээ эрхэлдэг 10 аж ахуйн нэгж, жижиг дэлгүүрүүд мөн “Ган талст-2” мал эмнэлэг, “Буян түгээгч” хийд, Ахмадын холбоо, Залуучуудын холбоо зэрэг бусад байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.

ЕБС-ийн хичээлийн I, II байр



Хотын Захирагчийн ажлын алба




Хүүхдийн Цэцэрлэг



Сум дундын эмнэлэг



Соёлын ордон



**“Хэнтий Ус” ХХК-ны харъяа
Бэрх хот дахь Дулааны станц**



Сум дундын Цагдаагийн тасаг



“Бэрх Уул” ХК

Онцгой байдлын 42-р гал унтраах, аврах анги



1. Нутаг дэвсгэр, Газар зүйн онцлог

Газарзүйн онцлог. Далайн түвшинээс дээш 1300-1500 м өргөгдсөн. Физик газарзүйн хувьд Дундад халхын болон Дорнод Монголын талархаг хээрийн мужид, геоморфологийн хувьд Онон Балжийн сав газарт багтдаг.

Газар хөдлөлийн эрчим 7 балл.

Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий тал хээр буюу мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой.

Цаг уурын нөхцөл

№	Насны ангилал	Эрэгтэй	Эмэгтэй
1	0-4 нас	127	90
2	5-9 нас	109	107
3	10-14 нас	101	93
4	15-19 нас	105	87
5	20-24 нас	98	95
6	25-29 нас	92	69
7	30-34 нас	73	78
8	35-39 нас	96	86
9	40-44 нас	90	88
10	45-49 нас	67	69
11	50-54 нас	78	72
12	55-59 нас	60	67
13	60-64 нас	39	52
14	65-аас дээш нас	41	84

15	Нийт	1176	1137
16	Өрхийн тоо	832	
17	Суурин хүн ам	2313	
18	Түр оршин суугч	157	

Хуурайдуу сэрүүн зунтай, хүйтэн өвөлтэй.

- 1 дүгээр сарын дундаж температур -20,6 °С
- 7 дугаар сарын дундаж температур +19,4 °С
- Хилийн дундаж салхины хурд 3,4 м/с
- Жилийн хур тундасны нийлбэр 189,5-195 мм

Газар нутаг

Нийт газар нутгийн хэмжээ 3986 га.

2. Хүн ам, өрхийн тоо

Тус хот нь Улаанбаатар хотоос 400 км-т оршдог. Нийт хүн амын 56% нь залуу болон дунд насныхан, 35% нь хүүхэд, 9% нь ахмад настан байна. Бэрх хот нь Уурхай түшиглэж боссон хот учир Монгол орны олон аймаг, сумаас ард иргэд шилжин суурьшсан онцлогтой хот юм. Тухайн орон нутагт олон жил ажилласан Орос үндэстэнгүүдээс орон нутагт суурьшиж одоог хүртэл амьдарч байгаа иргэд байдаг.

Бэрх хотын ард иргэд нь Шинэ жилийн баярыг бусад сумдуудаас илүү өргөн, онцлогтой тэмдэглэхээс гадна Хаврын баяр болох Наурызг орон нутагтаа өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлдэг.

Тус хотод **халх, казах, буриад, орос** зэрэг үндэстэн, ястануудаас бүрдсэн 2313 хүн ам оршин сууж байна.



2.1 КАЗАК ҮНДЭСТНИЙ ХАВРЫН БАЯР, НАУРЫЗ



3. ХОТЫН БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН

3.1 “Жонш” манай хотын брэнд бүтээгдэхүүн:

Эдүгээ манай хот нь 63 дахь жилдээ хайлуур жонш олборлож байгаа бөгөөд энэхүү солонго шиг өнгө өнгөөр алаглах эрдэнэс нь 15-р зуунийг хүртэл оноогдсон нэргүй явж байгаад өөрийнх нь харьцангуй хайламтгай чанар, түүний нэмц нь металлын хайлалтыг түргэтгэж шаарыг амархан ялгаруулдаг зэргээр нь Латинын /флор/ урсамтгай флорит гэсэн нэртэй болжээ. Хайлуур жонш нь металл бус ашигт малтмал бөгөөд манай улсын уул уурхайн салбарт экспортлож байгаа чухал үнэт түүхий эдийн нэг билээ Хайлуур жонш нь тунгалаг цагаан, ягаан, ногоон, шар, хүрэн зэрэг өнгө бүр байдаг, шил шиг гялтгандаг, тэгш биш хагаралтай хатуулаг нь 4, нягтрал нь 3.18 байдаг бутрамтгай эрдэс юм.

Хайлуур жоншийг хими, төмөрлөг, хөнгөн цагаан, оптик, лазерь, шил, паалангийн үйлдвэрт хэрэглэнэ. Мөн атомын эрчим хүчний үйлдвэрт ураны изотопыг ялгаруулахад ихээр хэрэглэж байна

Мөн Бэрхийн уурхайн жоншоор Бор-Өндөр сум болон орон нутгийн иргэд төрөл бүрийн ахуйн зориулалттай болон бэлэг дурсгалын зүйлсийг урлан бүтээж жоншний бас нэг гайхамшигт чанарыг нээж олны хүртээл болгож байгаа нь бахархуштай сайхан явдал юм.



3.2 Бөднө шувуу:

“Бөднө шувуут” ХХК нь 2013 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 6 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

“Бөднө шувуут” ХХК нь орон нутгийн өндөгний хэрэгцээг хангаад зогсохгүй Хэнтий аймаг, цаашлаад Улаанбаатар хотын 14 супермаркет сүлжээ дэлгүүрүүдээр борлуулж байна.

Бөднө шувууны өндөг нь хүний биеийн дархлааг сайжруулж,


.....
Борлуулдаг супермаркетуудаас дурьдвал: “Номин -5”, “Макс хүнс”, “Оргил худалдааны төв”, “Сансар”, “Every day” сүлжээ дэлгүүр, “Боса” худалдааны төв.

“Бөднө шувуут” ХХК нь 2014 онд “Монголын бизнес хөгжлийн гарц холбоо”-ны Монголын төлөө цом, өргөмжлөлөөр шагнагдсан.



3.3 Хөөрөг:

Тус хотын иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч Чойжилын Энхбаатар нь 1993 оноос хувиараа бизнес эрхэлж байгаа бөгөөд хөөрөгний жижиг дунд үйлдвэрлэлээ 2013 оноос эхлэн амжилттай эрхэлж байгалийн өнгөт чулууг ашиглан гоёлын хөөрөг хийж байна.



3.4 “Шоргоолжны үүр”:

Уг бүтээгдэхүүнийг “Шоргоолжны үүр” гэж нэрлэх болсон түүхээс: 1980-аад оны үед Уурхайн орос ажилтан хамт ажилладаг Монгол найзтайгаа үдийн цайгаараа эхнэрийнхээ хийсэн нарийн боовыг хамтдаа идсэн байна. Энэ үед уг нарийн боовыг түр газар тавиад авах гэтэл шоргоолж цугларсан байжээ. Монгол ажилтан хэд хоногийн дараа Орос ажилтнаас танай эхнэрийн хийсэн нөгөө шоргоолжны үүр шиг нарийн боов их амттай байсан шүү хийх аргыг нь сурах юмсан гэжээ. Энэхүү ярианаас хойш Бэрхийн ард түмэн Орос бүсгүйчүүдээс жорыг нь авч хийж сурснаар Хэнтий аймагт төдийгүй Улаанбаатар хотод брэнд болсон “Шоргоолжны үүр” нарийн боовыг амт, чанар сайтаа хийж байна. Уг “Шоргоолжны үүр” –ийг тус хотын ард, иргэд баяр, ёслолоор ширээгээ чимж заншсан болно.



3.5 Эсгий эдлэл:

Тус хотын иргэн С.Жавзмаа нь 1998 оноос одоог хүртэл эсгий эдлэл, гар урлалаар дагнан ажиллаж байна. Бүтээгдэхүүний гол түүхий эд нь нарийн ноос, бор, цагаан эсгий, савхи зэрэг бөгөөд 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн Бэрх хотод болон Хэнтий аймагтаа төдийгүй Улаанбаатар хотод захиалгаар борлуулж байна.

Энэ хугацаанд өөрийн хийж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээрээ 2015 онд Хэнтий аймгийн Чингис хотод зохиогдсон “Нэг суурин нэг бүтээгдэхүүн үзэсгэлэн”-гээс шилдэг бүтээгдэхүүн батламж, **Аймгийн Засаг даргын нэрэмжит хүндэт өргөмжлөл**, Бэрх хотын 2015 оны “Шилдэг бүтээгдэхүүн” –ээр шалгарч байсан. Эсгий эдлэлээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх сургалтыг орон нутагтаа амжилттай зохион байгуулж 10 иргэнийг хамруулаад байна.




ЭДИЙН ЗАСАГ

Хотын хэмжээнд нийт 9 аж ахуйн нэгж, 10 гаруй жижиг дэлгүүр үйл ажиллагаа явуулж улсад 83.1 сая, аймагт 124.3 сая, орон нутагт 40.7 сая нийт 248,1 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна.

4. Малын тоо, ангилал

Малын бүтэц



Малын тоог оруулна.

5. Түүхийн дурсгалт газрууд:

Бэрхийн уурхай эдүгээгийн Хэнтий аймгийн Батноров сумын нутаг хуучин Сэцэнхан аймгийн Сүжигт бэйсийн хошууны тахилга сүлдэт Мөнхцагаан уулаас хойхно, Суварган хөндийн зүүхэн жишгэр талд оршдог. Суварган хөндийд олон зууны турш ер бусын тохиолдлууд цөөн бус тохиожээ. Гурван зуун илүү жилийн тэртээ нарийн учир шалтгаанаар мэргэн лам Шаврангийн босгосон чулуун суварганы суурь буй. Түүний хажуухнаар уралдааны морин зам торго мэт хөвөрнө. Энэ нь Бэрхийн уурхайнхны наадмын уралдааны зам болно. Суварган хөндийд Хятадын орчин үеийн удирдагч Лин Бяогийн онгоц унаж дэлхийн түүхийн нэгэн тэмдэглэлт цэг үүсгэсэн юм. Хагас зууны турш өгөөж эрдэнэсээ тив дэлхийд хүртээсэн Бэрхийн уурхайн нөөц баялагийг суварган хөндийн гайхалтай тогтоц ид шидтэй холбох нь ч бий. Энэ уурхайд Монгол Зөвлөлтийн ажилчид 25 жил мөр зэрэгцэн ажиллаж байсан билээ. Монгол улсад Уул уурхайн салбарын голомтыг асаалцаж, улсын төсөв санхүүгийн тодорхой хувийг он удаан жил бүрдүүлж ирсэн Бэрхийн уурхай, Уурхайн тосгон, уурхайчдын алдрыг өнөд мөнхөлнө.



Уурхайчдын дурсгалд зориулсан дурсгалт хөшөө-2001.08 сар



1986 оны 08 сар

**Орос, Монгол улсын найрамдлыг
бэлгэдсэн дурсгал хөшөө**



1985 он "Алтан гадас" одонт

Бэрхийн уурхайн хаалга



2014 он 07 сар

Бэрхийн уурхай, Бэрх-Уул ХК-ны болон Бэрх хотын 60 жилийн ойг угтсан бүтээн байгуулалтын ажил Д.Чулуунбатын шүлэг Б.Сүхбаатарын ая "Уурхайчдын тосгон" дууны гэрэлт хөшөө

6. БАЙГАЛИЙН БАЯЛАГ, АШИГТ МАЛТМАЛЫН ОРД ГАЗРЫН ТУХАЙ

Геологийн тогтцоороо дэлхийд хосгүйд тооцогддог хайлуур жоншны ордтой. Хайлуур жонш, эрдэнэсийн арвин их уурхайн ордыг Бэрхийн уулын Жоншит толгойгоос жирийн малчин ажигч шинжээрээ анхлан нээж илрүүлсэн билээ. Монгол улсын өнгөт металлын ууган уурхай нь 1954 оноос хойш 400 метрийн гүнд хүртэл олборлолт хийж байсан юм. Одоо Бэрхийн уурхайд “Бэрх-Уул” ХК мөн уурхайн ашиглахгүй болсон газарт 20-иод бичил уурхай эрхлэгч “Нөхөрлөл”-үүд ажиллаж байна.

7. Өнөөдрийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа жижиг дунд үйлдвэрлэл

Өнөөдрийн байдлаар Бэрх хотод Талх нарийн боовны цех-3, Бөднө шувууны аж ахуй-1, Гахайн аж ахуй-2, Эсгий эдлэл, гар урлал-1, Оёдол-2, Хөөрөг гар урлал-1, Гутал засвар, оёдол-2 зэрэг жижиг дунд үйлдвэрлэлүүд үйл ажиллагаагаа явуулж байна.





ХОТЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВ:

Тус хот нь дараах гол зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Мал аж ахуйн түүхий эд бэлтгэлийн болон анхан шатны боловсруулалт хийдэг төвүүдийг байгуулж, Бэрх хотод мал аж ахуйн түүхий эд бэлтгэлийн бүсийн төв, Бэрх хотод аймгийн зүүн хойд сумдын мал аж ахуйн түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх үйлдвэртэй болох
- Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- Ажлын байрыг 50%-иар нэмэгдүүлэх
- Амьдралын тав тухтай орчныг бүрдүүлэх
- “Бэрхийн гүний уурхайн музей”-г байгуулах

Бэрх хотод байгуулагдах “Бэрхийн гүний уурхайн музей”-н ерөнхий санаа.

ТӨСӨЛ.

Дэлхийн ихэнх улс оронд түүхийн музей байдаг бөгөөд сан хөмрөг нь түүхэн үйл явдалтай холбоотой үзмэрүүд, археологийн олдворуудаас бүрддэг. Түүхийн музей нь түүхэн үйл явдал болсон орд харш, хаадын орд өргөөнд байх нь элбэг бол шинжлэх ухааны буюу байгалийн түүхийн музей нь амьтан, ургамал, хөрс шороо, хад чулуу, эрдэс чулуулгийн дээжээс сан

хөмрөг нь бүрдэж байдаг байна. Харин ашиглалт хийгдэж дууссан уурхайгаар музей хийж жуулчдыг татдаг хэд хэдэн орон байгаагаас хамгийн ойрын жишээг дурьдвал саяхан БНСУ-ын Кванмён хотын дарга Ян Гидэ монголд ирээд “Манай хотод 1912-1972 он хүртэл алт, мөнгө, хүрэл, цайр олборлодог уурхай байж байгаад 1972 оноос хойш 40 жил ашиглалтгүй агуулах хэлбэрээр байсан уурхайн цооногийг сэргээж кино театр, вионы музей болгон олонд хүртээл болгож жилдээ 2 сая орчим жуулчин хүлээн авдаг том хэмжээний бүтээн байгуулалт хийсэн Энэ уурхайн 40 жилийн бохирдлыг бүгдийг нь цэвэршүүлээд Тима паркийг бид байгуулсан. Ингэснээр аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж жилд 1.4 сая хүн зөвхөн Тима паркийг үзэхээр ирдэг болсон ба солонгосын аялал жуулчдын хамгийн их хайдаг 100 нэрний нэгэнд багтсан гэж хэлсэнээс харахад бидэнд ч бас боломж байгааг харуулж байна. Уг музейг Бэрх хоттой холбоотой УИХ-ын гишүүд, үе үеийн төрийн байгууллагын болон уурхайн удирлагууд, аймаг хотууд дахь нутгийн зөвлөл, инженер техникийн ажилчид, төр, иргэдийн оролцоотойгоор хамтран бүтээн босгож төрж өссөн, ажиллаж амьдарч байсан уурхайн жижиг суурингаа хөгжилд тэмүүлсэн амьдрал буцалсан орон нутгийн жишиг хот болгоход бидний энэхүү ажил хувь нэмэр оруулах боломжтой гэж үзэж байна.

